



УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/216

Улаанбаатар хот

Тусламж, үйлчилгээний
санхүүжилтийн журам батлах тухай

Монгол Улсын “Эрүүл мэндийн тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.4, 24.5, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, 21.5, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, “Эрүүл мэндийн даатгалын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 11.1, 12.1.1, 13 дугаар зүйлийн 13.1.9, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2015 оны 19, 23, 2016 оны 07, 19 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 224, 2016 оны 228, 2017 оны 48, 294 дүгээр тушаалууд, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 264/A/293 дугаар тушаал, Сангийн сайдын 2017 оны 216, Эмнэлгийн ерөнхий захирлын 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 199 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шинэчлэн баталсан, Монголын анагаах ухааны салбарт оношилгоо, эмчилгээний шинэ арга техник, технологи нэвтрүүлснээр, эмнэлгийн орчин үеийн, шинэ тоног төхөөрөмжөөр эмчилгээ оношилгоо хийх, эмчилгээний шинэ арга, технологийг шинээр нэвтрүүлэхэд шаардлагатай эм, урвалж, цацраг идэвхи бодисыг авах, мөн эмнэлгийн тусламж, үйлчилгээний ачаалал, хэрэгцээг шийдвэрлэх, эрэлтийг дэмжих шаардлагатай байгаа зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан “Тусламж, үйлчилгээний санхүүжилт”-ийг нэгдүгээр, “Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 264/A/293 тоот тушаалд заагдсан болон нэмэлтээр хийгдэх тусламж үйлчилгээний жагсаалт, тариф”-ийг хоёрдугаар, “ЭМД-тай хэвтэн эмчлүүлэгчдээс

000517

төлөх эмчилгээний зардлын 15 хувийн жагсаалт"-ыг гуравдугаар, "Төсөвт нийцүүлэн эмнэлзүйн албаны ажиллах орны тоо, нөхцөл сайжруулсан орны тоо, мөрдөх тариф"-ийг дөрөвдүгээр, "Ачаалал, хүлээгдэл, зохиомол эрэлт ихтэй, өндөр өртөгтэй, өнчин тоног төхөөрөмжийн оношилгоо, шинжилгээний жагсаалт, зохицуулалт тариф"-ийг тавдугаар, "Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгооны багцуудын үнийн жишиг тариф"-ийг зургаадугаар хавсралтаар тус тус баталж, 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Журмыг хэрэгжүүлж, тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй байхаар зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн захирал /Д.Чулуунбаатар/, Эмнэлзүй чанарын алба /Г.Болормаа/, Дотоод аудитор /Н.Сэлэнгэ/ болон төв, тасаг нэгжийн дарга, эрхлэгч, эмчийн багийн ахлагч, гишүүд нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тусламж, үйлчилгээний санхүүжилтийн орлогыг төсөвт төвлөрүүлэн, биелэлтийг улирал тутам тооцож ажиллахыг Стратеги төлөвлөлт эрхэлсэн захирал /Д.Далайжаргал/, Санхүү бүртгэлийн алба /Д.Хишигбаяр/, Эдийн засаг, төлөвлөлтийн алба /Г.Өлзийгаваа/-нд тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эмнэлгийн ерөнхий захирлын 2017 оны А/246 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОЧИРБАТ



Тусламж, үйлчилгээний санхүүжилт

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар УНТЭ-ээс иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2. Эрүүл мэндийн даатгалгүй үйлчлүүлэгч тушаалын хоёрдугаар хавсралтад заасан тарифын дагуу төлбөрийг бүрэн төлнө.
- 1.3. Эрүүл мэндийн сайдын 2016 оны 228 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралтад заагдсан гоо заслын эмчилгээ болон нөхөн сэргээх тусламж үйлчилгээ, зайн оношлогоо, нүдний хараа заслын лазер эмчилгээ, сайн дурын вакцинжуулалт, эрүүл мэндийн салбарт шинээр нэвтрүүлж буй монголд эмчлэгдэхгүй байгаа өвчин эмгэгийн оношлогоо, эмчилгээ, инноваци, технологи нэвтрүүлэлтийн төслийн хүрээнд хийгдэж буй эмчилгээ, оношилгоо, ажилбар, үйлчлүүлэгч өөрийн хүсэлтээр УНТЭ-т шатлал болон харъяалал алгасан үйлчлүүлж буй тохиолдолд тусламж үйлчилгээний төлбөрийг иргэн өөрөө хариуцна.
- 1.4. Дүүрэг болон аймгийн нэгдсэн эмнэлгээс илгээгдсэн үйлчлүүлэгчид эрүүл мэндийн анхан шатны суурь оношилгоо, шинжилгээг хийлгүүлэн, илгээсэн маягтын хамт тус эмнэлэгт хандана.
- 1.5. Эрүүл мэндийн байгууллагуудад үзүүлэх ерөнхий мэргэжлийн тусламж үйлчилгээнд давхардлыг арилгах, жигд хүргэх, аппарат тоног төхөөрөмжийн элэгдэл, үйлчилгээний ачаалалыг тэнцвэржүүлэх зорилгоор хөдөө орон нутгийн хүн амд ЭМД-аар, нийслэлийн иргэд өөрийн хүсэлтээр үйлчлүүлэх тохиолдолд төлбөр авна.
- 1.6. Одоо ажиллаж буй бүх шатны эмнэлгийн мэргэжилтнүүд ажлын газрын үнэмлэх, тодорхойлолтын хамт, тус эмнэлгийн үндсэн ажилчид ажлын газрын хүчинтэй үнэмлэхээр үйлчлүүлэх бөгөөд тусламж, үйлчилгээний төлбөрийг ЭМД-аас хөнгөлсний дараах мөнгөн дүнгийн 50-аас доошгүй хувийн хөнгөлөлт эдэлнэ. Санхүү бүртгэлийн алба нь энэхүү хөнгөлөлтийн тайланг тухай бүр Эдийн засаг төлөвлөлтийн албанд гаргаж өгнө.

Хоёр. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээлэл, орлогыг бүртгэх, төсөвт тусгах ажиллагаа

- 2.1. Тусламж, үйлчилгээний жагсаалт болон тарифыг үйлчлүүлэгчдэд ил газар байрлуулж, лавлагааг цахим бүртгэлийн бүртгэгч болон лавлагааны ажилтан хариуцан ажиллана.
- 2.2. Тусламж, үйлчилгээний орлогыг байгууллагын кассаар дамжуулан хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогын бүртгэлд бүртгэх, байгууллагын цахим

- бүртгэлийн болон санхүүгийн программыг ашиглан, төрийн сан дахь байгууллагын төсвийн харилцах дансанд төвлөрүүлэх ажлыг Санхүү, бүртгэлийн алба хариуцан зохион байгуулна.
- 2.3. Иргэдийн төлбөр төлсөн баримтад байгууллагын нэр, иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.
 - 2.4. Тасаг, нэгж төвүүдэд төлбөрийн тооцооны зөрчлийн эрсдлээс хамгаалах санамж бичиг болон тусламж үйлчилгээний тарифыг тасагт нь ил байрлуулна.
 - 2.5. Дурангийн мэс засал үргэлжлэх явцад зайлшгүй шаардлагаар нээлттэй аргад шилжсэн тохиолдолд хэрэглэсэн өртөг өндөр мэс заслын хэрэгслийн төлбөрийг тухайн даатгуулагчаар төлүүлнэ.
 - 2.6. Үйлчлүүлэгчдэд төлбөрийн буцаалт олгохдоо байгууллагын буруутай үйлдлээс бол 100% төлбөрийн буцаан олгоно. Үйлчлүүлэгчийн буруугаас бол 500 000 төгрөг хүртэлх үнийн дүнд 10%-ийн суутгал хийгдэх ба 500 000 төгрөгөөс дээш бол Эмнэлзүй эрхэлсэн захирлын удирдсан хурлын шийдвэрээр буцаан олголт хийгдэнэ.
 - 2.7. Нэмэлт болон төлбөрт тусламж үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой гарч байгаа шууд болон байгууллагын ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулна.

Гурав. Бусад

- 3.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжихгүй, төр даах хорт хавдрын эмчилгээ, оношилгооны үед хэрэглэгдэх эмнэлгийн хэрэгслүүд, тодосгогч бодис, хавдрын эмчилгээний химийн бодисын, зохиомол эрэлт, ачаалал, хүлээгдэл ихтэй, өндөр өртөгтэй, өнчин тоног төхөөрөмжийн оношилгоо, шинжилгээний төлбөрийг тухайн оны батлагдсан төсөв дэх улсын төсвөөс санхүүжүүлэх бүлэгт буй хэмжээнээс давсан, жил бүрийн төсвийн төлөвлөлтөөс давсан бол тавдугаар хавсралтын дагуу энэхүү журмын 2.6.1-ийг баримтлана.
- 3.2. Гадаадын зочин профессорын болон хамтын ажиллагаатай сургуулиудын саналыг үндэслэн үзлэг, оношилгоо шинжилгээ, эмчилгээний төрөл, мөрдөх төлбөрийн тарифыг тусгай гэрээгээр зохицуулна.
- 3.3. Жил болгон ЭМД-ын байгууллагатай тусламж үйлчилгээний гэрээ хийж, тусламж үйлчилгээний төрөл болгоноор санхүүжилт авах төлөвлөгөө гаргах ба төлөвлөгөөнөөс хэтэрсэн тохиолдолд иргэн өөрийн хүсэлтээр үйлчлүүлэх санал гаргавал тухайн тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлнэ.
- 3.4. Иргэн өөрөө амбулаториор болон хэвтэн эмчлүүлэх явцдаа эмчлэгч эмчийн бус өөр эмчийн заалт эсвэл өөрийн хүсэлтээр тарилга хийлгэх тохиолдолд зохих журмын дагуу тарианы өрөөнд үйлчлүүлнэ.

Дөрөв. Нэмэлт, нөхцөл сайжруулсан төлбөртэй өрөөний үйлчилгээ

- 4.1. Төлбөрт орны тоо нь эмнэлгийн батлагдсан нийт орны 10%-иас илүүгүй байна.
- 4.2. Төлбөрт орны төлбөрийг ахлах касс болон мөнгө хураах бүх цэгт хураана.
- 4.3. Даатгалын хэсэг кассанд тушаагдсан төлбөрт орны орлогыг эмчлүүлэгчийн өвчний түүхтэй тулгах, ор зохицуулалтын болон санхүүгийн програмд хамруулах, түүнд санхүү бүртгэлийн орлогын нягтлан бодогч хяналт тавина.
- 4.4. Хяналтын дүнгийн талаарх мэдээллийг Санхүү бүртгэлийн алба нь Стратеги төлөвлөлт эрхэлсэн захиралд, дэмжих үйлчилгээний багийн хуралд мэдээллийн урсгал хэлбэрээр тогтмол танилцуулна.
- 4.5. Эмнэлгийн дотоод журмыг зөрчсөн эмчлүүлэгчдэд төлбөрийг буцаан олгохгүй.

Тав. Аж ахуйн нэгж, байгууллагатай хийсэн гэрээгээр гүйцэтгэх урьдчилан сэргийлэх үзлэг, бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

- 5.1. Аж ахуйн нэгж байгууллагатай гэрээгээр гүйцэтгэх урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн бусад үйлчилгээг Эмнэлзүй эрхэлсэн захирал, Эмнэлзүй чанарын алба хариуцан зохион байгуулна.
- 5.2. Урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн бусад үйлчилгээг авах аж ахуйн нэгж байгууллага нь захиалгаа эмнэлгийн удирдлагад өгч, улмаар ЭЗТА холбогдох гэрээг байгуулж, баталсан хуваарийн дагуу үзлэг, тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 5.3. Аж ахуй нэгж байгууллага нь гэрээнд заасны дагуу төлбөр тооцоог эмнэлгийн дансанд шилжүүлнэ.
- 5.4. Урьдчилсан үзлэгийн тайланг Амбулаторийн тасаг Эмнэлзүй эрхэлсэн захирал болон Санхүү бүртгэлийн албанд дараа сарын 05-ны дотор тайлагнаж, архивт хувийг өгнө.

Зургаа. Иргэний хүсэлтээр гэрийн дуудлагаар үйлчлэх /103-ын дуудлагаас

бусад/

- 6.1. Үйлчлүүлэгч гэрийн дуудлагаар үйлчлүүлэх тохиолдолд эмнэлгийн Шуурхай удирдлагын төвд утсаар болон биеэр ирж мэдэгдэнэ.
- 6.2. Эмнэлзүй эрхэлсэн захирлын баталсан хуваарийн дагуу эмч дуудлаганд явах ба мэдээллийг Эмнэлзүйн зохицуулалтын тасгийн Шуурхай удирдлагын баг Санхүү бүртгэлийн албанд өгнө.
- 6.3. Дуудлаганд явсан эмч дуудлагын үзлэгийн тухай бүртгэл, тэмдэглэл хөтлөж Эмнэлзүй эрхэлсэн захиралд танилцуулна.
- 6.4. Гадаадын иргэнд үзлэг, үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд тарифын дагуу 30 000 – 50 000 төгрөгийг кассанд тушаалгана.

Долоо. Нэмэлт үзлэгийн зохицуулалт

- 7.1. Үйлчлүүлэгчдийн хүлээгдэл чирэгдэл бууруулах зорилготой ажлын цагт багтаан амбулаторын нэмэлт үзлэг, оношилгоог зохион байгуулж болно.
- 7.2. Амбулаторын төрөлжсөн мэргэжлийн эмчийн өдрийн нормативт үзлэгээс илүү хийсэн үзлэг, шинжилгээний тоог нэмэлт үзлэгт тооцно (Эмчийн багийн үзлэг хамаарахгүй).
- 7.3. Эмчийн үзлэгийн норматив Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын баталсан "Эмнэлзүйн үйл ажиллагааны нэгдсэн журам"-аар зохицуулагдана.
- 7.4. Нэмэлт үзлэг, оношилгооны тоог сар тутамд нийт үзлэгийн тоо, нормативт үзлэгийн тоо, нэмэлт үзлэгийн тоо, оношилгоо гэсэн үзүүлэлтээр гарган, амбулаторын эрхлэгчээр баталгаажуулан, Санхүү бүртгэлийн албанд гаргаж өгнө. Мэдээллийн хугацаа хоцроосон мэргэжилтэн хариуцлагыг хүлээнэ.

Найм. Хориглох зүйл

- 8.1. ЭМД-ын сангаас үзлэг, оношилгоо, шинжилгээнд олгож буй зардлыг даатгуулагчаас давхардуулан авах.
- 8.3 Үйлчлүүлэгчдээс жагсаалтанд зааснаас бусад тусламж үйлчилгээнд төлбөр, авах мөн эмч, мэргэжилтнүүд иргэдээс бэлнээр төлбөр тооцоо хийх
- 8.4 Ажлын байранд эм, биобэлдмэл, биологийн идэвхт бодис худалдаалах.
- 8.5 Тасаг нэгжтөлбөртэй орны батлагдсан тарифаас хэтрүүлэн төлбөр авах.
- 8.6 Улсын нэгдүгээр төв эмнэлэгт баримтлах "Эмийн бодлогын баримт бичиг"-т дурьдагдснаас бусад эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг иргэдээс гаргуулах.

Ес. Хяналт, үнэлгээ

- 9.1 Төлбөрт тусламж, үйлчилгээ нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, эмнэлгийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх зэрэг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүргийг байгууллагын Ерөнхий захирал хүлээнэ.
- 9.2. Төлбөрт тусламж үйлчилгээний орлого, зарцуулалтын үнэлгээний дотоодын хяналт, шинжилгээг улирал бүр, хөндлөнгийн (аудитын) үнэлгээг 2 жилд 1 удаа хийлгэнэ.
- 9.3. Төлбөрт тусламж, үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн болон орлого, зарцуулалтын тухай мэдээллийг нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллах үүргийн холбогдох албан тушаалтнууд хүлээнэ.

Арав. Журам зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага

Энэхүү журам зөрчсөн албан тушаалтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд УНТЭ-ийн "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасан сахилгын арга хэмжээ авч, хохирлыг буруутай этгээдээр төлүүлэн хөдөлмөрийн гэрээг цуцлах хүртэлх арга хэмжээг авна.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын 2018 оны 5р сарын/-ны өдрийн тушаалын хоёрдугаар хавсралт

Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 264/А/293 тоот тушаалд заагдсан болон нэмэлтээр хийгдэх тусламж үйлчилгээний үнийн жагсаалт, тариф

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
<i>Нэг. Оношилгоо, шинжилгээ</i>			
1.1	Лаборатори		
	<i>Клиник химийн шинжилгээ</i>		
1.1.1	Шээсний дэлгэрэнгүй шинжилгээ	4,000	
1.1.2	Нечипоренко	3,500	
1.1.3	Амбурж	3,500	
1.1.4	Зимницкийн сорил	3,500	
1.1.5	Гемосидерины сорил	3,500	
1.1.6	Порфирины сорил	3,500	
1.1.7	Бенс-Джонсоны сорил	3,500	
1.1.8	Үтрээний наалдацын шинжилгээ	4,500	
1.1.9	Өтгөнд далд цус тодорхойлох	3,500	
1.1.10	2 аяганы сорил	5,500	
1.1.11	3 аяганы сорил	7,000	
1.1.12	Үрийн шингэний ерөнхий шинжилгээ	8,000	
1.1.13	Түүрүү булчирхайн шүүрлийн шинжилгээ	8,000	
1.1.14	Тархи нугасны шингэний ерөнхий шинжилгээ	20,000	
1.1.15	Шүүдэст шингэний ерөнхий шинжилгээ	20,000	
	<i>Биохимийн шинжилгээ</i>		
1.1.16	Билирубин нийт	2,000	
1.1.17	Билирубин шууд	2,000	
1.1.18	АсАТ	2,000	
1.1.19	АлАТ	2,000	
1.1.20	Альбумин	2,000	
1.1.21	Нийт уураг	2,000	
1.1.22	Креатинин	1,500	
1.1.23	Сахар	2,500	
1.1.24	Шүлтлэг фосфотаза	1,500	
1.1.25	Аммони	6,000	
1.1.26	Амилаза	3,500	
1.1.27	Амилаза шээс	3,500	
1.1.28	Нойр булчирхайн амилаза	4,000	
1.1.29	Бикарбонат CO ₂	4,500	
1.1.30	Кальци	1,500	
1.1.31	Кальци шээсэнд	1,500	
1.1.32	Холестерин	2,000	
1.1.33	Холинэстераза	2,500	
1.1.34	Креатинфосфокиназа NAC	2,700	
1.1.35	Креатинфосфокиназа MB	4,000	
1.1.36	Креатинин шээсэнд	1,500	
1.1.37	Креатинин клиренс	3,000	

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
1.1.38	Үлдэгдэл азот	1,500	
1.1.39	Төмөр	2,500	
1.1.40	Нийт уураг /шээс/	7,800	
1.1.41	Нийт уураг /нугасны ус/	3,500	
1.1.42	Глутаматдегидрогенеза	2,500	
1.1.43	Сахар нугасны шингэнд	1,800	
1.1.44	ГГТ	1,500	
1.1.45	Шээсний хүчил /цус/	1,800	
1.1.46	Шээсний хүчил /шээс/	1,800	
1.1.47	Мочевин	2,000	
1.1.48	Мочевин шээсэнд	2,000	
1.1.49	ЛДГ	1,600	
1.1.50	Магни	2,000	
1.1.51	Магни шээсэнд	2,000	
1.1.52	Фосфор	1,500	
1.1.53	Фосфор шээсэнд	1,500	
1.1.54	Триглицерид	2,000	
1.1.55	Натри	6,000	
1.1.56	Кали	6,000	
1.1.57	Хлор	9,200	
1.1.58	Их нягтралтай липопротеин	6,000	
1.1.59	Бага нягтралтай липопротеин	11,000	
1.1.60	ASLO /ASO/ (тоогоор)	9,500	
1.1.61	С урвалжийн уураг /СРБ/ (тоогоор)	7,500	
1.1.62	Ревматоид фактор /РФ/ (тоогоор)	7,500	
1.1.63	GLDH	3,000	
1.1.64	Гомоцистейн	25,000	
1.1.65	B2 микроглобулин	25,000	
Биохимийн анализаторт хийгдэж байгаа иммунологийн			
1.1.66	Фруктозамин	1,500	
1.1.67	UBIC-Төмөр холбох чадвар	3,000	
1.1.68	Лактат	2,500	
1.1.69	Липаза	2,500	
1.1.70	Хүчиллэг фосфотаза	3,800	
1.1.71	Трансферрин	6,800	
1.1.72	α1 антитрипсин	7,500	
1.1.73	α1 микроглобулин	14,500	
1.1.74	α1 хүчиллэг гликопротеин	9,000	
1.1.75	Альбумин /шээс/	7,500	
1.1.76	Аполипопротеин А /АРОАТ/	6,800	
1.1.77	Аполипопротеин В /АРОВТ/	6,800	
1.1.78	Хавсарга С3	11,000	
1.1.79	Хавсарга С4	11,000	
1.1.80	Церулоплазмин	6,000	
1.1.81	Гаптоглобулин	10,000	
1.1.82	Гликолизсон гемоглобин	12,500	
1.1.83	Имуноглобулин А	10,000	
1.1.84	Имуноглобулин G	10,000	
1.1.85	Имуноглобулин M	10,000	
1.1.86	Карра	14,000	
1.1.87	Lambda	13,000	

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
1.1.88	Липопротейн А	6,800	
1.1.89	Миоглобин	14,000	
1.1.90	Преальбумин	4,800	
1.1.91	Soluble transferrin receptor	10,500	
1.1.92	Альбумин /нугасны ус /	7,500	
1.1.93	Иммуноглобулин G / нугасны ус /	10,000	
1.1.94	Лактат /нугасны ус/	2,500	
1.1.95	Амилаза /хэвлийн шингэн/	3,500	
1.1.96	Креатинин /хэвлийн шингэн/	1,500	
1.1.97	Нийт уураг /хэвлийн шингэн/	2,000	
1.1.98	Мочевин /хэвлийн шингэн/	2,000	
1.1.99	ЛДГ /плеврийн шингэн/	1,600	
1.1.100	Нийт уураг /плеврийн шингэн/	2,000	
1.1.101	Сахар /плеврийн шингэн/	2,500	
1.1.102	Сахар /үений шингэн/	2,500	
1.1.103	Иммуноглобулин А /үений шингэн/	10,000	
1.1.104	Иммуноглобулин G /үений шингэн/	10,000	
1.1.105	Иммуноглобулин M /үений шингэн/	10,000	
1.1.106	Лактат /үений шингэн/	2,500	
1.1.107	ЛДГ /үений шингэн/	1,600	
1.1.108	Нийт уураг /үений шингэн/	2,000	
1.1.109	Шээсний хүчил /үений шингэн/	1,800	
1.1.110	Хавсарга СЗ /үений шингэн/	11,000	
1.1.111	Натри /шээс/	6,000	
1.1.112	Кали /шээс/	6,000	
1.1.113	Хлор /шээс/	9,200	
1.1.114	Цистатин С	25,000	
1.1.115	Сийвэнгийн уургийн электрофорез	22,000	
1.1.116	Сийвэнгийн уургийн иммунотайпинг	86,000	
1.1.117	Гемоглобиний электрофорез	41,000	
1.1.118	Шээсний уургийн электрофорез	71,000	
1.1.119	Шээсний уургийн иммунотайпинг	106,000	
Бүлэгнэлтийн шинжилгээ			
Гемостазын ерөнхий шинжилгээ			
1.1.120	PT /INR/	3,500	
1.1.121	APTT	3,800	
1.1.122	Fibrinogen	4,200	
1.1.123	TT	3,800	
Гемостазын өвөрмөц шинжилгээнүүд			
1.1.124	II factor	35,000	
1.1.125	V factor	35,000	
1.1.126	VII factor	35,000	
1.1.127	VIII factor	35,000	
1.1.128	IX factor	35,000	
1.1.129	X factor	35,000	
1.1.130	XI factor	35,000	
1.1.131	Protein C	94,000	
1.1.132	Antitrombin III	35,000	
1.1.133	Heparin	21,000	
1.1.134	Von Willebrand factor	28,000	
1.1.135	Free Protein S	92,000	

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
1.1.136	Antiplasmin	19,000	
1.1.137	Plasminogen	21,000	
1.1.138	D-Dimer	44,000	
1.1.139	LA /Lupus Anticoagulant/	41,000	
1.1.140	Collagen/EPI Test	132,000	
1.1.141	Collagen/ADP Test	132,000	
Гематологийн шинжилгээ			
1.1.142	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ (20 үзүүлэлт)	5,000	
1.1.143	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ (26 үзүүлэлт)	8,000	
1.1.144	Ретикулоцит тоолох (анализатораар)	5,000	
1.1.145	Лейкограмм (захын цусны түрхэц)	10,000	
1.1.146	УЭТХ (СОЭ)	2,000	
1.1.147	Цитохимийн урвал	8,000	
1.1.148	Миелограмм (ясны хэмийн шинжилгээ)	15,000	
1.1.149	Цочмог лейкоз оношилгоо	601,000	
1.1.150	Архаг лейкоз оношилгоо	601,000	
1.1.151	Лимфоцитын субтип (ТВНК)	142,000	
Имунофенотипийн шинжилгээний үнийн задаргаа			
Урвалжууд (antibody)			
PerCP	CD45 (хуруу шилний тоогоор үржүүлнэ)	23,900	
FITC	CD34	17,300	
	CD20	17,300	
	CD13	12,500	
	CD7	22,500	
	CD4	17,500	
	CDK/L	29,500	
	CD38	30,500	
	PE	CD14	19,800
CD117		12,500	
CD56		8,900	
CD22		20,000	
CD5		20,000	
CD10		25,300	
CD8		20,000	
Glycophorin A		29,000	
APC	CD3	12,500	
	HLA-DR	22,000	
	CD19	20,800	
	CD138	43,200	
Бусад	CD33	15,500	
	IgG1 FITC	8,900	
	IgG1 APC	22,120	
	IgG1 PE	11,500	
	Falcon tube (хуруу шилний тоогоор үржүүлнэ)	700	
Бусад зардал		50,000	
Нэг (antibody)-ийн үнэнд нэмж бусад зардлын төлбөр нэмэгдэнэ			
Эд нийцлийн шинжилгээ			
Эдийн тохироо үзэх			
1.1.152	HLA typing / ABDR/	350,000	
1.1.153	HLA C typing	80,000	
1.1.154	HLA DQ typing	115,000	

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
1.1.155	HLA DP typing	98,000	
1.1.156	DSA	128,000	
1.1.157	Ab screening I class	30,000	
1.1.158	Ab screening II class	30,000	
1.1.159	PRA I class	250,000	
1.1.160	PRA II class	250,000	
1.1.161	Single antigen I class	282,000	
1.1.162	Single antigen II class	240,000	
1.1.163	MIC antibody screening	158,000	
1.1.164	KIR typing	93,000	
1.1.165	Cross match	136,000	
1.1.166	B27 SSP typing	105,000	
Эмийн тун үзэх			
1.1.167	Циклоспорины түвшин тогтоох	50,000	
1.1.168	Такролимусын түвшин тогтоох	80,000	
1.1.169	Сиролимусын тун үзэх шинжилгээ	45,000	
1.1.170	ММФ тун үзэх шинжилгээ	45,000	
1.1.171	Ванкомицины эмийн түвшин тогтоох	50,000	
Иммунологийн шинжилгээ			
1.1.172	HBsAg cassette	4,000	
1.1.173	anti - HCV cassette	4,000	
1.1.174	HIV cassette	4,000	
1.1.175	anti-TB cassette	4,000	
1.1.176	Troponin cassette	6,000	
1.1.177	TPHA	4,000	
1.1.178	RPR	4,000	
1.1.179	LE эс тоолох	6,000	
Вирусын маркер			
1.1.180	anti - HAV Ig M	25,000	
1.1.181	HBsAg	8,000	
1.1.182	HBsAg quant (тоогоор)	40,000	
1.1.183	anti - HBs	12,000	
1.1.184	anti - HBc Ig M	12,000	
1.1.185	anti - HBc	12,000	
1.1.186	HBeAg	18,000	
1.1.187	anti - HBe	18,000	
1.1.188	anti - HCV	21,000	
1.1.189	ДОХ /HIV combi/	11,000	
1.1.190	Цитомегаловирус CMV Ig G	15,000	
1.1.191	Цитомегаловирус CMV Ig M	15,000	
Бамбайн гормон			
1.1.192	TSH	10,000	
1.1.193	T3	10,000	
1.1.194	Чөлөөт T3 /FT3/	10,000	
1.1.195	T4	9,000	
1.1.196	Чөлөөт T4 /FT4/	9,000	
1.1.197	T-uptake	16,000	
1.1.198	anti-TPO	15,000	
1.1.199	Тироглобулины эсрэг бие /anti TG/	15,000	
1.1.200	Anti-TSHR	46,000	
1.1.201	Тироглобулины /TG/	18,000	

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
	Гормонууд		
1.1.202	Кортизол /Cortisol/	12,000	
1.1.203	АТКГ /ACTH/	20,000	
1.1.204	Инсулин /Insulin/	15,000	
1.1.205	С пептид /C-peptide/	18,000	
1.1.206	HCG+b II	10,000	
1.1.207	FSH	12,000	
1.1.208	LH	12,000	
1.1.209	Prolactin	12,000	
1.1.210	Estradiol	12,000	
1.1.211	Progesteron	15,000	
1.1.212	Testosteron	15,000	
1.1.213	DHEA-S	15,000	
1.1.214	SHBG	15,000	
	Хавдрын маркерууд		
1.1.215	Элэгний хавдар AFP	12,000	
1.1.216	Бүдүүн гэдэсний CEA	15,000	
1.1.217	Түүрүү булчирхай PSA	15,000	
1.1.218	Free PSA	15,000	
1.1.219	Cyfra 21-1	25,000	
1.1.220	NSE	18,000	
1.1.221	Хөхний CA 15-3	21,000	
1.1.222	Нойр булчирхайн CA 19-9	17,000	
1.1.223	Өндгөвч CA 125-II	17,000	
1.1.224	Ходоод CA 72-4	20,000	
1.1.225	S100	42,500	
1.1.226	P1NP	23,000	
	Харшил		
1.1.227	Ig E	12,000	
	Зүрхний маркер		
1.1.228	Troponin T	20,000	
1.1.229	Digoxin	11,500	
1.1.230	pro BNP	78,000	
1.1.231	anti-CCP	50,000	
	Ясны маркер		
1.1.232	b Crosslaps	24,000	
1.1.233	N-MID Osteocalcin	20,000	
1.1.234	PTH	20,000	
1.1.235	Vitamin D Total	40,000	
1.1.236	procalcitonin	58,000	
	Анеми		
1.1.237	Ferritin	18,000	
1.1.238	B 12	15,000	
1.1.239	Folate	15,500	
	Бусад халдвар үүсгэгчид		
1.1.240	Toxo IG M	15,000	
1.1.241	Toxo IG G	15,000	
1.1.242	HSV 1 Ig G	15,000	
1.1.243	HSV 2 Ig G	15,000	
1.1.244	HSV 1 Ig M	15,000	
1.1.245	HSV 2 Ig M	15,000	

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
	ELISA, иммунофлюоресценсийн аргаар		
1.1.246	H.pylori Ig G / ELISA /	8,000	
1.1.247	anti-ds DNA	15,000	
1.1.248	pANCA	25,000	
1.1.249	cANCA	25,000	
1.1.250	EBV VCA IgM	18,000	
1.1.251	EBV VCA IgG	12,000	
1.1.252	EBNA 1 IgM	18,000	
1.1.253	EBNA 1 IgG	18,000	
1.1.254	EBV EA DR	18,000	
1.1.255	EBV heterophil ab	18,000	
1.1.256	anti-phospholipid ab IgM/IgG	34,000	
1.1.257	anti-HDV	17,000	
1.1.258	anti-HEV	17,000	
1.1.259	LKM antibody	17,000	
1.1.260	CMV antigenemia	50,000	
1.1.261	ANA	15,000	
1.1.262	AMA	15,000	
1.1.263	ASMA	15,000	
1.1.264	APCA	15,000	
1.1.265	TB IFN gamma	220,000	
	Иммуногематологийн шинжилгээ		
1.1.266	Цусны бүлэг		2,000
1.1.267	Rh фактор	3,000	
1.1.268	Цусны хувийн тохироо		10,000
1.1.269	anti-A титр		6,500
1.1.270	anti-B титр	10,000	
1.1.271	Улаан эсийн эсрэгбие илрүүлэлт		26,000
1.1.272	Улаан эсийн эсрэгбие ялган дүйлт		26,000
1.1.273	Кумбсын шууд болон шууд бус урвалын шинжилгээ хийх (тус тусдаа)		23,000
	Молекул-биологи		
1.1.274	HCV RNA тоолох	145,000	
1.1.275	HBV DNA тоолох	125,000	
1.1.276	Hemavision	751,000	
1.1.277	CMV DNA тоолох /Roche RT PCR/	220,000	
1.1.278	EBV DNA тоолох	100,000	
1.1.279	БК вирус тоолох сийвэнд	100,000	
1.1.280	БК вирус тоолох шээсэнд	100,000	
1.1.281	Bcr/Abl гений шинжилгээ	150,000	
1.1.282	AmL/ETO гений шинжилгээ	220,000	
1.1.283	AML-ETO Real time PCR kit	220,000	
1.1.284	PML-RARA Real time PCR kit	220,000	
1.1.285	TEL/AML Real time PCR kit	220,000	
1.1.286	JAK2 V617F Real time PCR kit	220,000	
1.1.287	NPM1 Mut A/B genotyping kit	220,000	
1.1.288	FLT3 KTD/ITD PCR kit	220,000	
1.1.289	BAALC real time PCR	220,000	
1.1.290	WT1 real time PCR	220,000	
1.1.291	C-kit Realt time PCR	220,000	

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
1.1.292	CBFB-MYH11 real time PCR	220,000	
1.1.293	MPL W515L/K real time PCR	220,000	
Бактериологи шинжилгээ			
1.1.294	Цэрний нян судлалын шинжилгээ	14,000	
1.1.295	Хатгалтын шингэний нян судлалын шинжилгээ (хэвлий,плевр, тархи нугасны шингэн, үений	14,000	
1.1.296	Бусад нян судлалын шинжилгээ	11,000	
1.1.297	Цусны нян өсгөвөрлөх шинжилгээ	51,000	
1.1.298	ХТН илрүүлэх шинжилгээ	5,000	
1.1.299	Сорьцыг грамын аргаар шинжлэх	3,000	
Эд, эсийн шинжилгээ			
1.1.300	Эсийн шинжилгээ бэлтгэж онош дүгнэлт өгөх		20,000
1.1.301	Нарийн зүүний хатгалтын шинжилгээ хийх FNA		40,000
1.1.302	Эдийн шинжилгээ бэлтгэж онош дүгнэлт өгөх/зөөлөн эд, бүх төрлийн дурангаар авсан эд/		23,000
1.1.303	Ясны хэмийн эсийн шинжилгээ авах, лабораторид шинжлэх/эм эмнэлгийн хэрэгслийн		50,000
1.1.304	Ясны хэмийн эсийн шинжилгээ авах, лабораторид шинжлэх/эм эмнэлгийн хэрэгслийн		80,000
1.1.305	Имуногистохимийн шинжилгээ хийх/маркерын тооноос шалтгаална/		150,000
1.1.306	Арьсны эдийн шинжилгээ авах, шууд тархан туяарах будгийн аргаар эдийг бэлтгэх, онош		60,000
1.2 Цөмийн оношилгоо			
1.2.1	Ачаалалтай зүрхний бичлэг	35,000	
1.2.2 Зүрхний булчингийн цусан хангамжийн скинтиграфи			
1.2.2.1	Б.Ачаалалгүй /тайван/	95,000	
1.2.2.2	А.Ачаалалтай /ачаалалтай/	120,000	
1.2.3	Нулимсны хүүдийн (дакро) скинтиграфи	55,000	
1.2.4	Бамбайн иод шингээлт тодорхойлох	40,000	
1.2.5	Бамбайн динамик скинтиграфи	60,000	
1.2.6	Элэг цөсний динамик скинтиграфи	80,000	
1.2.7	Хөхний скинтиграфи	80,000	
1.2.8	Бөөрний динамик скинтиграфи	80,000	
1.2.9	Бөөрний каптоприлт динамик скинтиграфи	80,000	
1.2.10	Бөөрний диуретик динамик скинтиграфи	80,000	
1.2.11	Бөөрний статик скинтиграфи	60,000	
1.2.12	Уушигны цусан хангамжийн скинтиграфи	80,000	
1.2.13	Уушигны агааржилтын скинтиграфи	80,000	
1.2.14	Бүх биеийн ясны скинтиграфи /СПЕКТ-КТГ/	80,000	
1.2.15	Зүрхний үйл ажиллагааны радионуклид вентрикул	80,000	
1.2.16	Бамбайн хорт хавдрын дахилт, үсэрхийллийг шал	120,000	
1.2.17	Бамбайн дэргэдэх булчирхайн скинтиграфи /СПЕ	100,000	
1.2.18	Тархины скинтиграфи	120,000	
1.2.19	T3	15,000	
1.2.20	T4	15,000	
1.2.21	FT4	15,000	
1.2.22	TSH	15,000	
1.2.23	PSA	20,000	

Жич: Шаардлагатай тохиолдолд компьютер томографийн шинжилгээ хийлгэхэд нэмэлт төлбөр 60 000₮-г төлнө.

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал

1.3	Эндоскопи		
1.3.1	Гастроскопия Видео	50,000	
1.3.2	Колоноскопия Видео	60,000	
1.3.3	Бронхоскопия Видео	60,000	
1.3.4	ERCР цөс, нойр булчирхайн замыг тодосгон шинжлэх (тодосгогч бодисын үнэ ороогүй)	600,000	
1.3.5	EMR	600,000	
1.4	Эхосонографи		
1.4.1	Хэвлийн эрхтнүүдийн хэт авиан оношилгоо	20,000	
1.4.2	Бамбай булчирхайн хэт авиан оношилгоо	20,000	
1.4.3	Үтрээний хэт авиан оношлогоо	20,000	
1.4.4	Шулуун гэдсээр түрүү булчирхайг харах	20,000	
1.4.5	Шулуун гэдэсний хэт авиан оношилгоо		20,000
1.4.6	Улаан хоолойн дурантай Эхо		20,000
1.4.7	Захын судасны хэт авиан оношилгоо		
1.4.8	Хүзүү толгойн багц	25,000	
1.4.8.1	Гарын	25,000	
1.4.8.2	Хөлийн	25,000	
1.4.9	Зүрхний ЭхоКГ	30,000	
1.4.10	Ачаалалт ЭхоКГ	40,000	
1.4.11	Хатгалт, биопси /биопси зүүний үнэ ороогүй/	40,000	
1.4.12	Контраст Эхо /бодисын үнэ ороогүй/	40,000	
1.4.13	Эндоваскуляр Эхо	40,000	
1.5	Радиологийн тасаг		
1.5.1.	Харалт		
1.5.1.1.	Дижитал рентген харалт (эрхтэн харгалзахгүй)	15,000	
1.5.2.	Улаан хоолой, ходоод гэрэлд харж, зураг авах		
1.5.2.1.	Гэрэлд харах (Тодосгогч барийн сульфатын үнэ о	15,000	
1.5.2.2.	Дижитал зураг авах (эрхтэн харгалзахгүй)	25,000	
1.5.3.	Бүдүүн гэдэс гэрэлд харж, зураг авах		
1.5.3.1.	Гэрэлд харах (Тодосгогч барийн сульфатын үнэ о	15,000	
1.5.3.2.	Дижитал зураг авах (эрхтэн харгалзахгүй)	25,000	
1.5.4.	Пассаж үзэх, зураг авах		
1.5.4.1.	Харах (Тодосгогч барийн сульфатын үнэ ороогүй)	15,000	
1.5.4.3.	Дижитал зураг авах (эрхтэн харгалзахгүй)	25,000	
1.5.5.	Тодосгогч бодистой Рентген гэрэлд харах, зураг, авах (Холецистопанкреотохолангографи, Дакроцистографи, ретроградная пиелография, Фистулографийн зураг, Гистеросальпингографийн зураг) /тодосгогч		
1.5.5.1.	Харах (Тодосгогч бодис болон барийн сульфатын	15,000	
1.5.5.2.	Дижитал зураг авах (эрхтэн харгалзахгүй)	25,000	
1.5.6.	Зураг авалт		
1.5.6.1.	Дижитал рентген зураг авалт (1 байрлал нь, эрхтэ	15,000	
1.5.6.2.	Дижитал рентген зураг авалт (2 байрлал нь, эрхтэ	25,000	
1.5.6.3.	Бөөрний үйл ажиллагааны цуврал зураг (1-р цувр	15,000	
1.5.6.4.	Бөөрний үйл ажиллагааны цуврал зураг (2-р цувр	25,000	
1.5.6.5.	Бөөрний үйл ажиллагааны цуврал зураг (3-р цувр	35,000	
1.5.6.6.	Бөөрний үйл ажиллагааны цуврал зураг (4-р цувр	45,000	

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
1.5.6.7.	Бөөрний үйл ажиллагааны цуврал зураг (5-р цувр)	50,000	
1.5.6.8.	Бүсэлхий нурууны дижитал рентген зураг 1-р байр	20,000	
1.5.6.9.	Бүсэлхий нурууны дижитал рентген зураг 2-р байр	25,000	
1.5.6.10.	Бүсэлхий нурууны дижитал рентген зураг 3-р байр	35,000	
1.5.6.11.	Бүсэлхий нурууны дижитал рентген зураг 4-р байр	45,000	
1.5.6.12.	Бүсэлхий нурууны дижитал рентген зураг 5-р байр	55,000	
1.5.6.13.	Бүсэлхий нурууны дижитал рентген зураг 6-р байр	60,000	
1.5.6.14.	Хүзүүний дижитал рентген зураг 1-р байрлал эгц	20,000	
1.5.6.15.	Хүзүүний дижитал рентген зураг 2-р байрлал хажуу	25,000	
1.5.6.16.	Хүзүүний дижитал рентген зураг 3-р байрлал баруун	35,000	
1.5.6.17.	Хүзүүний дижитал рентген зураг 4-р байрлал зүүн	40,000	
1.5.6.18.	Сээр нурууний дижитал рентген зураг 1-р байрлал	20,000	
1.5.6.19.	Сээр нурууний дижитал рентген зураг 2-р байрлал	25,000	
1.5.6.20.	Сээр нурууний дижитал рентген зураг 3-р байрлал	35,000	
1.5.6.21.	Сээр нурууний дижитал рентген зураг 4-р байрлал	40,000	
1.5.7.	Нэмэлт үйлчилгээ		
1.5.7.1.	Хэвтэн эмчлүүлэгч өөрийн хүсэлтээр рентген зургаа дискэнд бичүүлэх	2,500	
1.5.7.2.	Амбулаториор үйлчлүүлсэн даатгуулагч өөрийн хүсэлтээр рентген зургаа дискэнд бичүүлэх	2,500	
1.6	Зүрхний үйл онош		
1.6.1	ЭКГ		5,000
1.6.2	Ачаалалт сорил	40,000	
1.6.3	Холтер	40,000	
1.6.4	Флиботомия /эм нэмэлт шаардлагатай зүйлсийн ү	20,000	
1.6.5	Артерийн даралт 24 цагийн хяналт	30,000	
1.7	Мэдрэлийн үйл онош		
1.7.1	Тархины цахилгаан бичлэг /ЭЭГ/		30,000
1.7.2	Тархины судасны бичлэг /доплер/	30,000	
1.7.3	Тархины судасны дуплекс шинжилгээ	30,000	
1.7.4	Булчингийн бичлэг /EMG/	суурь үнэ 40000 дараагийн булчин бүр 3000	
1.7.5	Захын мэдрэлийн бичлэг /ENG/	4,000	
1.7.6	Полисомнографи /PSG/	150,000	
1.7.7	Нойрны ЭЭГ	70000 /2 цаг/	
1.7.8	Харааны дуудлагат потенциал /VEP/	25,000	
1.7.9	Сонсголын дуудлагат потенциал /AEP/	24,000	
1.7.10	Мэдрэхүйн дуудлагат потенциал /SSEP/	24,000	
1.7.11	Тархи нугасны шингэн авах	20,000	
1.8	Уушгины үйл онош		
1.8.1	Спирограмм		16,000
1.8.2	Утлага эмчилгээ	5,000	
1.8.3	Транс торакаль биопси	350,000	
1.8.4	Бронх альвеолярный лаваж /шил орсон/	60,000	
1.9	Чих хамар хоолой, сонсгол, дуу авиан оношилгоо		
1.9.1	Аудиометрийн шинжилгээ	20,000	
1.9.2	ABR /Дунгийн дуудлагат потенциалын шинжилгээ	50,000	
1.9.3	ОЕА /Дунгийн гаднах эсийн үйл ажилллагааны ши	50,000	

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
1.9.4	ASSR /Тайван үеийн сонсголын ерөнхий шинжил	60,000	
1.9.5	Тимпанометр	20,000	
1.9.6	Сонсголын гуурс хийлэх	10,000	
1.9.7	Сонсголын тусгай сорилууд	25,000	
1.9.8	Чихний дуран	25,000	
1.9.9	Төвөнхийн дуран	30,000	
1.9.10	Хамрын дуран	30,000	
1.10	Бөөрний мэс заслын кабинет		
1.10.1	Оношилгооны шулуун дуран	50,000	
1.10.2	Оношилгооны уян дуран	70,000	
1.10.3	Шинжилгээ авах / түрүү булчирхайн шүүрлийн-/	30,000	
1.10.4	Шинжилгээ авах / үрийн шингэний /		45,000
1.10.5	Урофлоуметр / Гуурсны үнэ ороогүй/	50,000	
1.11	Харшил		
1.11.1	Сорилууд /1 төрөл/	3,000	
1.12	Диабетийн төв		
1.12.1	Диабатын оношилгооны багц /Хөлийн мэдрэхүй шалгах үзлэг/	25,000	
1.12.2	Глюкозын ачаалалтай сорил хийх	14,000	
1.12.3	Захын судсанд глюкоз тодорхойлох	2,500	
1.12.4	Бодисын солилцоо тодорхойлох	5,000	
1.12.5	Түргэвчилсэн аргаар HbA1c үзэх	15,000	
1.12.6	Түргэвчилсэн аргаар өөх тосны үзүүлэлт тодорхойлох	15,000	
1.12.7	Бамбайн биопси хийх/хэрэгсэл орохгүй/	20,000	
Хоёр. Амбулаторын эмчилгээ			
2.1	Цөмийн онош зүй		
2.1.1	Бамбайн хордлогот бахууг Иод-131-ээр эмчлэх	200,000	
2.1.2	2 см-ээс дээш хэмжээтэй олон зангилаат бахууг эмчлэх	250,000	
2.1.3	Бамбайн хорт хавдрын эмчлэх Иод-131-ээр эмчлэх		
2.1.3.1	30 mCi /идэвх/	500,000	
2.1.3.2	50 mCi /идэвх/	980,000	
2.1.3.3	75 mCi /идэвх/	1,470,000	
2.1.3.4	100 mCi /идэвх/	1,960,000	
2.2.	Дурангийн эмчилгээ		
2.2.1	Тариа хийх		
	Хурц цус алдалт	150,000	
	Шарх	150,000	
	УХӨВенийн судас хатууруулах	150,000	
2.2.2	Цахилгаан түлэлт	150,000	
2.2.3	Аргонплазм ашиглан түлэх		
	Цус алдалт	150,000	
2.2.4	Хавдрын улмаас бөглөрсөн хөндийт эрхтний бөглөрлийг түлж канал гаргах	200,000	
2.2.5	Барретийн улаан хоолойг эрт үед түлж эмчлэх	300,000	
2.2.6	Салст хуулах хагалгаа /ESD/	800,000	
2.2.7	Видеодуоденоскоп ашиглан цэсний ерөнхий цоргоос чулуу авах хөхлөгийн нээлт /ERSP-EST/	1,200,000	
2.2.8	Стент тавих /улаан хоолой, ходоод-гэдэс/	1,500,000	

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
2.2.9	Баллон дилтаци /буж/	300,000	
2.2.10	Нарийслийг зүсэх	150,000	
2.2.11	УХӨВенийн судас боох /Band ligator/	250,000	
2.2.12	Гадны биетийг авах	250,000	
2.2.13	Полипэктоми	250,000	
2.2.14	Бронхосанац	50,000	
2.2.15	Эндобронх, эмчилгээ	6,000	
2.3	Ерөнхий мэс заслын кабинетэд хийгдэх эмчилгээ		
2.3.1	Хатиг, арьсан дорхи буглаа нээх		22,000
2.3.2	Шарханд анхдагч, хоёрдогч цэгцлэлт хийх		22,000
2.3.3	Сорви авах /1см/		22,000
2.3.4	Гигром, атром авах		23,000
2.3.5	Арьсан доорхи, хумсан доорхи ясанд орсон хэлбэрийн үед нээлт хийх		23,000
2.3.6	Хэвлий, цээжний хөндийд пункци хийх		23,000
2.3.7	Асцитын үед хэвлийн хөндийн шингэн авах		23,000
2.3.8	Өөхөн хавдар авах 5 см хүртэл		23,000
2.3.9	Өөхөн хавдах авах 5 см дээш		30,000
2.3.10	Хурууны 1-2 үе тайрах		30,000
2.3.11	Идээлсэн атром авах		31,000
2.3.12	Суганы булчирхай авах		31,000
2.3.13	Спираль тавих /нарколог эмчийн заалттай тохиолдолд/		31,000
2.3.14	Мастит нээх /1 хөх/	50,000	
2.3.15	Мастит нээх /2 хөх/	100,000	
2.3.16	Хөндийт бус эрхтэнд орсон гадны биетийг рентген хяналтын дор авах	50,000	
2.3.17	Боолт хийх /нэг удаа/		3,000
2.3.18	Бамбайн хатгалт /зүү орохгүй/	20,000	
2.4	Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын кабинет		
2.4.1	Шулуун гэдэсний ур авах	30,000	
2.4.2	Шулуун гэдэсний ургацаг /хэсгийн	80,000	
2.4.3	Шулуун гэдэсний ургацаг /нугасны	120,000	
2.4.4	Шамбарамын бүлэн авах/хэсгийн	50,000	
2.4.5	Шамбарамын бүлэн авах/нугасны мэдээгүйжүүлэгтэй/	90,000	
2.4.6	Хярзангийн ур авах	50,000	
2.4.7	Шулуун гэдэсний болон эдийн буглаа нээх/хэсгийн мэдээгүйжүүлэгтэй/	60,000	
2.4.8	Шулуун гэдэсний болон эдийн буглаа нээх/нугасны мэдээгүйжүүлэгтэй/	100,000	
2.4.9	Архаг мундасын үед идээт цорго авах мэс засал	100,000	
2.4.10	Шамбарамын зангилаанд хатаах тариа хийх /склеротерапия/		85,000
2.4.11	Шамбарамын I, II үед зангилаанд резинэн боолт тавих /нугасны мэдээгүйжүүлэгтэй/		140,000
2.4.12	Шамбарамын I, II үед зангилаанд резинэн боолт тавих/соок-нэг удаагийн нугасны	150,000	
2.4.13	Шамбарамын I, II зэргийн үед сорвижуулах	150,000	
2.4.14	Хэт улаан туяагаар шамбарам шарах		180,000

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
2.4.15	Боолт хийх /нэг удаа/		3,000
2.4.16	Хошног арьсны унжлага авах /хэсгийн мэдээгүйжүүлэгтэй/	80,000	
2.4.17	Хошног арьсны унжлага авах /нугасны мэдээгүйжүүлэгтэй/	100,000	
2.4.18	Хошногны цууралтыг өөлж авах /хэсгийн мэдээгүйжүүлэгтэй/	100,000	
2.4.19	Хошногны цууралтыг өөлж авах /нугасны мэдээгүйжүүлэгтэй/	100,000	
2.4.20	Хошногны цууралтыг өөлж + хошногны хуниас булчинг хажууд сэтлэх /нугасны	200,000	
2.4.21	нугасны мэдээгүйжүүлэгтэй/ Фистултоми, фистулэктоми	110,000	
2.4.22	Шулуун гэдэсний нийлмэл цоргонд сетон тавих /нугасны мэдээгүйжүүлэгтэй/	160,000	
2.4.23	Шулуун гэдэсний нийлмэл цоргоны сетон солих ба авах /нугасны мэдээгүйжүүлэгтэй/	100,000	
2.4.24	Хүндрээгүй үү авах	100,000	
2.4.25	Шулуун гэдэсний эдийн шинжилгээ авах /хэсгийн мэдээгүйжүүлэгтэй/	80,000	
2.4.26	Шулуун гэдэсний эдийн шинжилгээ авах /нугасны мэдээгүйжүүлэгтэй/	120,000	
2.5	Нүдний кабинет		
2.5.1	Нүдний алимны зөөлөн эдэд тариа (холимог) хийх (парабульбар смесь тарих)		8,500
2.5.2	Нүдний алимны араар (ретробульбар) тариа хийх		8,000
2.5.3	Эвэрлэг, салстаас гадны биет авах		25,000
2.5.4	Нулимсны зам сэтгүүрдэж угаах		20,000
2.5.5	Дээд ба доод зовхины өвдөг нээх		35,000
2.5.6	Халазион нээх		35,000
2.5.7	Зовхины булчирхайд массаж хийх		15,000
2.5.8	Нүдэнд давхраа хийх		150,000
2.5.9	Торлогийн лазер хийх		75,000
2.5.10	ЯАГ лазераар капсултоми хийх /нэг нүдэнд/	80,000	
2.5.11	Яаг лазераар иридэктоми хийх /нэг нүдэнд/	80,000	
2.6	Эрүү нүүрний мэс засал		
	Шүдний кабинет		
	Эмчилгээний 1-р багц		
2.6.1	Эмчийн үзлэг	Эхний 2 үзлэг ЭМДын сангаас санхүүжүүлж буй хэмжээгээр. 3 дахь үзлэгээс төлбөрөө үйлчлүүлэгч өөрөө хариуцна.	
	Мэдээ алдуулалт		
	Хөндий нээж цэвэрлэх		
	Суваг өргөсгөх, угаах		
	Эм, түр ломбо тавих		
	Эмчилгээний 2-р багц		
	Эмчийн үзлэг	Эхний 2 үзлэг ЭМДын сангаас санхүүжүүлж	
	Мэдээ алдуулалт		

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
2.6.2	Шүдний суваг угаах	Буй хэмжээгээр. 3 дахь үзлэгээс төлбөрөө үйлчлүүлэгч өөрөө хариуцна.	
	Өргөсгөж хатаах		
	Сувгийн ломбо тавих		
Шүдний зарим оношилгоо, эмчилгээ			
2.6.3	Саатсан агт араа, хүндрэлтэй, бусад эмнэлгийн хугалсан шүд авах	100,000	
2.6.4	Өнгөц	Цоорол	15,000
2.6.5	Дунд		18,000
2.6.6	Гүн		20,000
2.6.7	1 сурвалжтай	Зөөлцийн үрэвсэл	37,000
2.6.8	2 сурвалжтай		60,000
2.6.9	3 сурвалжтай		70,000
2.6.10	1 сурвалжтай	Холбоосын үрэвсэл	32,000
2.6.11	2 сурвалжтай		44,000
2.6.12	3 сурвалжтай		60,000
2.6.13	Цемент	Байнгын ломбо тавих	5,200
2.6.14	Глассиономер		5,500
2.6.15	Өөрөө хатуурагч хуванцар		6,000
2.6.16	Гэрлээр хатуурагч хуванцар		14,000
2.6.17	Хуучин ломбо авах		3,000
2.6.18	Бүтэн шүдний хөндий нээх		6,000
2.6.19	Эмчилгээний жийргэвч	Түр ломбо	3,000
2.6.20	Тусгаарлах жийргэвч		3,000
2.6.21	Ломбо		2,000
2.6.22	Мэдээ алдуулах	Сувгийн эмчилгээ	2,000
2.6.23	Мышьяк тавих/хүнцэл/		3,500
2.6.24	Шүдний хөндийг нээх		3,000
2.6.25	Зөөлц авах /1 суваг/		2,500
2.6.26	Суваг өргөсгөх, цэвэрлэх/1 суваг/		2,500
2.6.27	Шүдний сувгийн эм солих /давтан/		2,000
2.6.28	Шүдний суваг ломбодох/1 суваг/		4,000
2.6.29	Сувгийн хуучин ломбо авах / 1 суваг/		4,000
2.6.30	Шүдний чулуу цэвэрлэх/1 шүд/	Шүдний тойрон эдийн эмчилгээ	1,500
2.6.31	Буйланд эм тавих, шавхлага хийх/1 удаа/		2,000
2.6.32	Салстын эмчилгээ/1 удаа/		5,000
2.6.33	Шүдний хатуу эдэд лак, гель түрхэх	Амны хөндийн үйлчилгээ	3,500
2.6.34	Шүд цайруулах эмчилгээ/бүрэн/		180,000
2.6.35	Шүдний сувгаар цайруулах эмчилгээ/1 шүд/		50,000
2.6.36	Голонцортой шүд хийх		30,000
2.6.37	Шүдний паалан тавих		28,000
2.6.38	Силант хийх		5,000
2.6.39	Бүх шүдний өнгөлгөө хийх		15,000
2.6.40	Шүдний буйлны эмгэг хөндийг хусаж цэвэрлэх SRP/1 шүд/		3,000
2.6.41	Хүүхдийн сүүн шүдний металл түр бүрээс /1 шүд/		20,000
2.6.42	Байнгын шүд авах		15,000
2.6.43	Сүүн шүд авах	8,000	

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф	
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал
2.6.44	Буруу байрлалтай, хүндрэлтэй шүд авч, оёдол	Мэс ажилбар	20,000
2.6.45	Саатсан араа далд ургалттай		39,000
2.6.46	Хөндлөн байрлалтай шүд авах		80,000
2.6.47	Хэлний хөвч уртасгах		39,000
2.6.48	Салстын уйланхай авах		29,000
2.6.49	Шүдний гаралтай ясны хальсны идээт үрэвсэл		15,000
2.6.50	Буглаа нэвчдээс, хажиг мундас нээх		15,000
2.6.51	Эрүүний ясны хугаралд чиг тавих		40,000
2.6.52	Шүд авсан ором цэвэрлэх		5,000
2.6.53	Гэмтлийн гаралтай шарханд оёдол		25,000
2.6.54	Мэдээ алдуулах		5,000
2.6.55	Шүд авсны дараах цус тогтоох		5,000
2.6.56	Хагас болон бүрэн мултарсан шүдэнд чиг тавих		38,000
2.6.57	Буйл тайрах		25,000
2.6.58	Альгоголизаци ба хориг хийх		25,000
2.6.59	Туушин засах		30,000
2.6.60	Тулгуур эдийн хагалгаа хийх/1шүд/		30,000
2.6.61	Шүдний имплант хийх/1 шүд/		1,300,000
2.6.62	Шүдний суурийн оройн уйланхай авах		50,000
2.6.63	Брекет системийн эмчилгээ хийх		480,000
2.6.64	Гингвозктомия, Гингвотомия/буйл тайрах, томорсон буйл авах/		15,000
2.6.65	Сиалографи хийх/шүлсний булчирхайн тодотгогч бодис шахаж зураг авах/	35,000	
2.6.66	1 шүдтэй шүдэлбэр	Уян тагнаатай авагддаг шүдэлбэр	40,000
2.6.67	2 шүдтэй шүдэлбэр		45,000
2.6.68	3 шүдтэй шүдэлбэр		50,000
2.6.69	4 шүдтэй шүдэлбэр		55,000
2.6.70	5 шүдтэй шүдэлбэр		60,000
2.6.71	6 шүдтэй шүдэлбэр		65,000
2.6.72	7 шүдтэй шүдэлбэр		70,000
2.6.73	8 шүдтэй шүдэлбэр		75,000
2.6.74	9 шүдтэй шүдэлбэр		80,000
2.6.75	10 шүдтэй шүдэлбэр		85,000
2.6.76	11 шүдтэй шүдэлбэр		90,000
2.6.77	12 шүдтэй шүдэлбэр		95,000
2.6.78	13 шүдтэй шүдэлбэр		100,000
2.6.79	14 шүдтэй шүдэлбэр		105,000
2.6.80	Дээд	Цутгамал суурьтай авагддаг	300,000
2.6.81	Доод		250,000
2.6.82	Шаазан бүрээс	Авагддаггүй шүдэлбэр	300,000
2.6.83	Цутгамал ган бүрээс		100,000
2.6.84	Алт монетон бүрээс/үнэт металлын хувь хүн		100,000
2.6.85	Хуванцар бүрээс		80,000
2.6.86	1 шүдтэй шүдэлбэр		18,000
2.6.87	2 шүдтэй шүдэлбэр	Шахмал хуванцар	21,500
2.6.88	3 шүдтэй шүдэлбэр		25,000
2.6.89	4 шүдтэй шүдэлбэр		28,000
2.6.90	5 шүдтэй шүдэлбэр		31,000
2.6.91	6 шүдтэй шүдэлбэр		34,500
2.6.92	7 шүдтэй шүдэлбэр		37,500

Д/д	Тусламж, үйлчилгээ	Тариф		
		Нэмэлт	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 264/А/293 тоот тушаал	
2.6.93	8 шүдтэй шүдэлбэр	суурьтай авагддаг шүдэлбэр	41,000	
2.6.94	9 шүдтэй шүдэлбэр		44,000	
2.6.95	10 шүдтэй шүдэлбэр		47,000	
2.6.96	11 шүдтэй шүдэлбэр		50,000	
2.6.97	12 шүдтэй шүдэлбэр		54,000	
2.6.98	13 шүдтэй шүдэлбэр		57,000	
2.6.99	14 шүдтэй шүдэлбэр		60,000	
2.6.100	Бүрэн шүдтэй шүдэлбэр		120,000	
2.6.101	Тэлэгч эрэг		Согог гажиг засал авдаг зэмсэг	20,000
2.6.102	Тэлэгч пурш			5,000
2.6.103	Хуруун пурш	4,000		
2.6.104	Түлхэгч пурш	5,000		
2.6.105	Уруулын нум	6,000		
2.6.106	Адамсын дэгээ	3,000		
2.6.107	Нүд хэлбэрийн дэгээ	4,000		
2.6.108	Цэцгэн дэгээ	3,000		
2.6.109	Суман дэгээ	3,000		
2.6.110	Зэллэсэн дэгээ	3,000		
2.6.111	Суурь ялтас	8,000		
2.6.112	Хазалтын налуу	10,000		
2.6.113	Хазалтын хавтгай	10,000		
2.6.114	Зөөлөн хэв	3,700		
2.6.115	Туслах материал	1,000		
2.6.116	Толгойн боолт татлага	28,000		
2.6.117	Нүүрний маск татлага	40,000		
2.6.118	Ховхорсон брекет	3,000		
2.6.119	Нэмэлт хэсэгтэй нум	5,000		
2.6.120	Уруулын даравч	3,500		
2.6.121	Хацрын хөндийрүүлэгч	3,000		
2.6.122	Чулуун загвар	10,000		
2.6.123	MRC/гажиг заслын зэмсэг/	150,000		
2.6.124	Ялтсан зэмсэг	40,000		
2.6.125	Микро имплант	80,000		
2.6.126	Онош тогтоох	10,000		
2.6.127	Загвар	7,000		
2.6.128	Хэв	3,000		
2.6.129	Брекет/ган/	300,000		
2.6.130	Банд	7,000		
2.6.131	Нум/1 ширхэг/	6,500		
2.6.132	Холбогч резин, татлагын резин/1 ширхэг/	2,500		
2.6.133	Зай гаргагч резин, металл зай гаргагч/1 ширхэг/	500		
2.6.134	Брекет наах/1 ширхэг/	5,000		
2.6.135	Брекет систем /металл/	530,000		
